

## ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛ, ӨРГӨТГӨЛИЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ

1. Ду600мм-ийн ил шугамын дулаалга хэсэгчлэн солих /1100м/ ажлыг “Термобазальт” ХХК гүйцэтгэж хийснээр Ду600-н 3,5 км шугамын дулаалгын ажил бүрэн дуусч, шугамын дулаан нэвтрүүлэх чадвар нэмэгдсэн сайн ажил болсон.
2. Бид 2026 оноос 2 Ду 400мм-ийн шугамын дулаалга шинэчлэх /1000м/ ажлыг үе шаттайгаар солихоор 2026 оны их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 295,0 сая төгрөгт тусгасан.
3. 2025 онд Техникийн усны нөөц шугам барих ажлыг /5,2 км/ Орхон аймгийн хөрөнгө оруулалтаар “Ахин Ундрах” ХХК ажлын гүйцэтгэгчээр шалгарч, зураг төсвийн дагуу ажлыг гүйцэтгэн 95%-ийн гүйцэтгэлтэй явж байна.
4. Орхон аймаг Баян-Өндөр сум Баянцагаан баг Дулааны төв шугам сүлжээний Ф720х8.0 мм-ийн 3,2 км шугамын өргөтгөлийн ажлыг “Эрин гүрэн” ХХК гүйцэтгэсэн. Төсөвт өртөг: 4,3 тэрбум. Станцын урд талын А1001 замыг 4 эгнээ болгож өргөтгөхтэй холбоотойгоор аркийн хэсгийн шугамын ажил хүлээгдэж байна. Гагнуурын оёдол дээр ЭХХТ хяналт тавьж ажилласан.
5. Төв дулаан цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл, ус дулаан дамжуулах төв барих Наран, Цагаанчулуут баг Ф273мм-ийн 1,7 км шугамын өргөтгөлийн ажлыг “Эрин гүрэн” ХХК гүйцэтгэсэн. Шинэ ЦТП /Солонго захын урд талд/ баригдаж тоног төхөөрөмжүүд угсрагдсан. Манай насос станцаас Онцгой байдлын цаад талын ДХ-12-д шугам холбогдож ус тавьсан.

Цаашид жил дараалан аймагтай хамтран Эрдэнэт хотын инженерийн шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх ажлыг зохион байгуулан ажиллахаар төлөвлөж байна.



## ДОТООД ХЭРЭГЦЭЭНИЙ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧИЙГ ХЭМНЭХ

Уур, усны алдагдлыг бууруулах, ДХЦЭХ-ний хэрэглээг хэмнэх төлөвлөгөөг 2025.03.23, 2025.09.26-ны өдрүүдэд батлуулан сарын аяны тайланг 2025.05.10, 2025.11.06-ны өдөр нэгтгэж удирдлагуудад танилцуулав.

4-р сар болон 10-р сарын аяны хүрээнд 19 албан шаардлагаар 77 гэмтлийг илрүүлэн цаг алдалгүй устгуулан ажилласан.

### 2025 оны 4-р сарын аяны ДХЦЭХ-ийг хэмнэх хүрээнд:

- Зуухнуудын горимд хяналт тавьж, тоос ахиулан тээрмийг зогсоож (400кВт) үндсэн тоноглолоос 305 цагаар бага ажиллуулж,  $305 \text{ цаг} * 400 \text{ кВт} = 11,765,680.0$  төгрөгийн хэмнэлт гаргасан.
- Мазут аж ахуйн жижиг насос явуулж  $720 \text{ цаг} * 7,5 \text{ кВт} = 5400 \text{ кВт} * 96,44$  төгрөг = 520,776.0 төгрөгийн хэмнэлт гаргасан.
- Гадна талбайн гэрэлтүүлгүүд фото релетэй учир харанхуй болоход асч, гэгээ ороход унтардаг.
- Өмнөх оны 4 дүгээр сартай харьцуулахад үндсэн дамжлага 108 цагаар бага, вагон хөмрөгчийн тоноглол 224 цагаар бага ажилласан.
- ПЭН, СЭН-ний сэлгэн залгалт хийгдээгүй нь ДХЦЭХ-г хэмнэсэн.

### Уур, ус хэмнэх хүрээнд:

- Гүний худаг №3-ыг ажилд явуулж 1024 тн усыг тунгаасан усны бассейнд нэмж, 89,312,720.0 төгрөгийн хэмнэлт гаргасан.
- Градерийн хаяж байгаа усыг тунгаасан усны насосны сорох талд холбож, хими цех рүү түүхий усанд өгч ГОК-оос авах Станцын техникийн ус хэмнэсэн тооцоог гаргахад  $G = 15,738$  тн/цаг техникийн ус хэмнэсэн

### **2025 оны 10-р сарын аяны ДХЦЭХ-ийг хэмнэх хүрээнд:**

- ✓ **Уур, усны алдагдлыг бууруулах аяны хүрээнд:**
  - а) Техникийн усыг 54,5 тн буюу 1,014,255.0 төгрөгөөр хэмнэж ажилласан.
  - б) 50 тн-ын 2 бакыг ажилд залгаж 22 хоног ашигласнаар 929,295.84 төгрөгийн хэмнэлт гаргасан.
  - в) Гүний усны насос №3,5,7-г ажилд явуулж 5320 тн усыг тунгаасан усны бассейнд нэмж, 398,012.72 төгрөгийн хэмнэлт гаргасан.
  - д) Хими цех нь БЗК-ийн түвшин гаргасан тул сарын хугацаанд хоногийн 4,19 цаг буюу 130 цаг зогсоосноор 4,930,550.0 төгрөгийн хэмнэлт гаргасан. Нийт—7,272,113.56 төгрөг
- ✓ **ДХЦЭХ-г хэмнэх хүрээнд:**
  - а) Гадна талбайн гэрэлтүүлгүүд фото релетэй учир харанхуй болоход асч, гэгээ ороход унтардаг. Турбин цех нарны панелийн гэрэл 24ш, складны 16ш, коридорийн 8ш, өрөөний гэрэлтүүлэгүүдэд 16ш лед гэрэл суурилуулснаар 1,024,056.0 төгрөгийн хэмнэлт гаргасан.
  - б) Зуухнуудын горимд хяналт тавьж, тоос ахиулан тээрмийг сарын аяны хугацаанд ээлжинд 2-3 цаг зогсоож, 26,656,016.0 төгрөгийн хэмнэлт гаргасан.
  - в) Энэ сарын 23ш вагоныг гараар буулгаснаар 888,186.0 төгрөгийн хэмнэлт гаргасан.
  - д) Хими цех нь БЗК-ийн түвшин гаргасан тул сарын хугацаанд хоногийн 4,19 цаг буюу 130 цаг зогсоосноор 1,498,195.0 төгрөгийг тус тус хэмнэсэн байна. Нийт—30,066,453.0 төгрөг

## **ХЭМНЭЛТТЭЙ, ҮР АШИГТАЙ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ ЗАМААР ШИНЭЧЛЭЛИЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ**

2025 онд Хүнд механизмын парк шинэчлэлийн хүрээнд LIEBHERR PR 736 маркийн бульдозерыг 1,7 тэрбум төгрөгт төлөвлөн томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн. Энэ LIEBHERR PR 736 маркийн бульдозер нь БМ10 маркийн ОХУ-н бульдозероос бүтээмж өндөр, үр ашигтай, түлш зарцуулалт 2 дахин бага, хүний ажиллах орчныг бүрдүүлснээр маш давуу талтай шинэ техник технологи нэвтрүүлсэн ажил болсон.

Бид 2011 оноос хойш 7 зуухны хяналт удирдлагыг компьютерын хяналт удирдлагын системд шилжүүлэхээр зорьж ажиллан 5 зуухны удирдлагыг сүүлийн үеийн дэвшилтэт технологи болох PLC программчлагддаг логик контроллёрын удирдлагаар шинэчлэн сольж ажиллаж байна. 2025 онд Зуух №7-н хэмжүүр, автоматик, алсын удирдлагыг компьютерын хяналтын системд шилжүүлж, ажилд явуулан амжилттай хүлээн авч ажиллалаа.

Мөн хөдөлгүүрүүдийг үе шаттай шинэчлэх ажлууд хийгдэж байна. Цаашид бид IE3 тэмдэглэгээтэй өндөр үр ашигтай, дулаан бага гаргадаг, цахилгаан эрчим хүчийг илүү хэмнэдэг, удаан эдэлгээтэй хөдөлгүүрүүдийг хөрөнгө оруулалтаар авахаар төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.

Эргэлтийн насос болох Grundfos насосыг 2011 оноос хойш “Эргэлтийн ус”, “Аваарын маслын нэмэлт ус”, “Дотоод хэрэгцээний сүлжээний ус”, “БЗК насос №1,2,3”, “Түүхий ус №1,2,3”, “Нам цэгийн бак”-ны насосуудад тавьж, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэн ажиллаж байна. Уг Grundfos насос нь дуу чимээний түвшин бага, бат бөх бүтэцтэй, эрчим хүчний зарцуулалт бага, ашиглалтын хугацаа урт, асаалтын үеийн гүйдэл бага шаарддаг, удаан хугацаанд найдвартай ажиллах чадвартай, засвар үйлчилгээ хийхэд хялбар, гэмтэл бага гардаг, их засварын зардлыг хэмнэж ажиллаж байгаа нь маш том давуу тал юм. 2024 онд “Эргэлтийн ус №3 Д-320-50 маркийн насос”-ыг давтамж хувьсгуургүй TP 300-290/4 A-F-A-BAQE-UW3 сольж ажилд оруулсан. 2025 онд “Дренажийн бакны №2 К-45-55 насос”-ыг евростандартын грундфосс насосоор солих /TP 80-400/2 A-F-A-BAQE-OW1 давтамж хувьсгуургүй/ төлөвлөн, худалдан авах ажиллагаа хийгдэж байна. Цаашид энэ ажлыг үргэлжлүүлэн үе шаттай төлөвлөж ажиллана.

2024 онд зууханд дуу намсгагч төхөөрөмж хийхээр судлан, зуух №1,2-ын хооронд 1 ширхэг дуу намсгагч төхөөрөмж хийж хэрэгжүүлсэн. Дуу намсгагч төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр зуух галлах, зогсоох үед гардаг өндөр хэмжээний (115дБ-ээс дээш) дуу шуугианы бохирдлыг багасгаж байгаа нь хэмжилтээр болон бодит байдал дээр батлагдсан тул 2025 онд нэмж 2 ширхэг дуу намсгагч төхөөрөмжийг 2 зуухны хооронд хийж дуусгаад байна. Энэ тоног төхөөрөмжийг гаднаас маш өртөг өндөртэй буюу 100-120 сая төгрөгөөр авах судалгаа хийгдсэн. Иймээс төхөөрөмжийг өөрсдийн нөөц бололцоог ашиглан өөрийн хөрөнгө оруулалтаар шийдэж, 19,0 сая төгрөгт төсөвлөн хийж байна. Нийт 6 зуухны дунд 3 ширхэг дуу намсгагч төхөөрөмж хийж шинээр нэвтрүүлснээр станцын ойр орчмын айл өрхийн тайван байдал, ажилчдын эрүүл мэнд, ажиллах орчныг сайжруулан 300-иад сая төгрөгийн хэмнэлт гарган ажиллаж байна.

2025 онд Техник зохион байгуулалтын ажлын хүрээнд 7 ажил төлөвлөөд 5 ажил бүрэн хийгдсэн, 2 ажлын гэрээ хийх түвшинд явж байна.

№	ХИЙГДЭХ АЖИЛ	НЭГЖ	ТОО	ҮНЭ	БИЕЛЭЛТ
1	Вагон хөмрөгчийн бутлагч фрезерийн машин ДФМ-1 хөдөлгүүр редукторууд, цахилгааны кабель удирдлагын хэлхээг бүрэн шинэчлэх	КОМ	1	109,000.0	Гэрээ хийгдсэн
2	Зуух №7 ДМС I, II хурд, тосон таслуурыг вакуум таслуурт шилжүүлэх	КОМ	2	77,100.0	Хийгдсэн 100%
3	НОВ ХХБ-д 0,4 кВ-ын ЭВУЗ-660В-1600А автоматыг шинэчлэх	Ш	2	40,600.0	Хийгдсэн 100%
4	Дотоод хэрэгцээний хяналтын системийг компьютерын хяналт удирдлагад шилжүүлэх	КОМ	1	39,400.0	Хийгдсэн 100%
5	Ду 600мм-ийн ил шугамын дулаалга хэсэгчлэн солих /1100м/	КОМ	1	513,000.0	Хийгдсэн 100%
6	Зуухан цехийн гүүрэн кран №1-ийн кабин доторх удирдлагын хэсэг, цахилгааны щит шинэчлэх, цонхны шил сольж, кондишн суурилуулах	КОМ	1	40,000.0	Гэрээ хийгдсэн
7	Галын дохиоллын өргөтгөлийн ажил	КОМ	1	113,500.0	Хийгдсэн 100%

ИНЖЕНЕРИЙН АЛБА

## ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

### АЖИЛТНУУДЫН МЭРГЭЖЛИЙН БОЛОН УДИРДАХУЙН АРГА БАРИЛ ЭЗЭМШҮҮЛЭХ ХИМИ ЦЕХЭД ХИЙГДСЭН АЖИЛ

1. Хими цехийн хамт олон нь 2025-11-20ны өдөр ахмад ажилтнуудаа урьж "Өвлөн суралцах" өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгөөр ахмад ажилтнууддаа шинэ техник технологи ажиллагаагаа танилцуулж, хуучин ажлын байранд нь нэг өдөр ажиллуулаа. Ахмад ажилтнууд маань хуучин ажлаа хийхийн зэрэгцээ шинэ залуу ажилтнууддаа мэдлэг туршлагаасаа зааж, хөгжилтэй явдалаа дурсан ярьсан нэгэн сайхан ажлын өдөр боллоо.



## 2025 ОНЫ 02-Р УЛИРЛЫН ШИНЭЭР АЖИЛТНУУДЫН СУРГАЛТЫН ТАЙЛАН

Сургалтыг 2025.05.06,07-ны өдрүүдэд ХНА зөвлөх инженер М.Цэрэнбалжир, Т.Ууганцэцэг, ХАБЭА-н инженер О.Отгон-Эрдэнэ, эмнэлгийн анхны тусламжийн хичээлийг ХНА З.Цогзолмаа, байгууллагын гэрээт галын улсын байцаагч У.Оюунбат нар хамтран доорхи сэдвүүдээр зохион байгуулав.

- ✓ Компанийн бүтэц, зохион байгуулалт, танилцуулга, технологи ажиллагаа, дулаан, цахилгааны схем,
- ✓ Цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа
- ✓ Дулаан механикийн тоноглолд ажиллах ААД
- ✓ ХАБЭА-н хууль, эрсдэлийг бууруулах, аюулыг таних, мэдээллэх
- ✓ Эмнэлгийн анхны тусламж
- ✓ Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, хэрэглэгдэж байгаа галын хорны тип, маяг ажиллах зарчим
- ✓ Эрчим хүчний үйлдвэрийн ИТА, ажиллагсдын дунд зохиох үндсэн дүрэм
- ✓ Бүтээмж, хувь хүний хариуцлага хандлагын талаар 16 цагийн сургалтыг зохион байгуулж, дотор тоноглолоор танилцах аяллалыг хийцгээлээ.



## 2025 ОНЫ 04-Р УЛИРЛЫН ШИНЭЭР АЖИЛТНУУДЫН СУРГАЛТЫН ТАЙЛАН

Сургалтыг 2025.12.04,05-ны өдрүүдэд ХНА зөвлөх инженер Т.Ууганцэцэг, ХАБЭА-н инженер Ё.Тунгалаг, УЗНН-ийн ажилтан Б.Золжаргал, байгууллагын гэрээт галын улсын байцаагч У.Оюунбат нар хамтран доорхи сэдвүүдээр 2 өдрийн 16 цагийн сургалтыг зохион байгуулав.

- ✓ Компанийн бүтэц, зохион байгуулалт, танилцуулга, технологи ажиллагаа, дулаан, цахилгааны схем,
- ✓ Цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа
- ✓ Дулаан механикийн тоноглолд ажиллах ААД
- ✓ ХАБЭА-н хууль, эрсдэлийг бууруулах, аюулыг таних, мэдээллэх
- ✓ Эмнэлгийн анхны тусламж
- ✓ Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, хэрэглэгдэж байгаа галын хорны тип, маяг ажиллах зарчим
- ✓ Эрчим хүчний үйлдвэрийн ИТА, ажиллагсдын дунд зохиох үндсэн дүрэм



## ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

### АЖИЛТНУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ САЙЖРУУЛАХ, ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛГООР ХИМИ ЦЕХЭД ХИЙГДСЭН АЖИЛ

1. Хими цехийн хамт олон нь 2025-10-11-ны өдөр Химичдийн зөвөлгөө-2025 өдөрлөг зохион байгуулав. Өдөрлөгөөр өдөрлөгийг нээж хими цехийн дарга Х.Болормаа 2025 оны ололт амжилт, цаашид хийж хэрэгжүүлэх зүйлсийн талаар ярилцаж, ашиглалт-засварын инженерийн Ш.Отгонцэцэг ажилтнуудад химийн үелэх сисметийн талаар мэдээлэл хүргэв. Ажилтнууд технологи ажиллагааны талаар ярилцаж, шинэ залуу ажилтанууддаа туршлагаасаа хуваалцсан, хамтран зүтгэгч нартаа сэтгэлийн үгсээ хэлсэн, ажилтнуудаа урамшуулан шагнасан сайхан өдөрлөг зохион байгууллаа.



**“ЭДЦС” ТӨХК-ИЙН ХЭМЖЭЭНД ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ЭРҮҮЛ АХУЙН СЭДЭВТ “ЦЕНТАВР” УДИРДАМЖИТ ТЭМЦЭЭНИЙГ  
ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ТАЙЛАН**

Дотоод хяналтын хэлтсийн батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу компанийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сэдэвт “Центавр” удирдамжит тэмцээнийг 2025 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 09<sup>20</sup> - 11<sup>50</sup> цагийн хугацаанд компанийн хурлын зааланд амжилттай зохион байгууллаа.

Тэмцээнд тус компанийн цех тус бүрийн багуудаас гадна алба, хэлтсийн хамтарсан нэг баг, нийт 9 баг оролцсон. Үүнд:

❖ “Dark flame” баг	(Түлш дамжуулах цех)
❖ “Fire” баг	(Зуухан цех)
❖ “Илч - Энерги” баг	(Турбин цех)
❖ “Electro” баг	(Цахилгаан цех)
❖ “Secure X” баг	(Хими цех)
❖ “Мэдрэмж” баг	(ДХХА цех)
❖ “Джоуль” баг	(ДШС цех)
❖ “Genius squad” баг	(Механик цех)
❖ “Таван Од” баг	(Алба, хэлтэс)

“Центавр” тэмцээнд багууд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дараах сэдвийн хүрээнд мэдлэг, мэдрэмжээ сорин өрсөлдлөө.

Сэдэв №1 Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, цахилгаан станц, дулааны шугам сүлжээний дулаан-механикийн тоноглолын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм, цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм;

Сэдэв №2 Хөдөлмөрийн тухай болон ХАБЭА тухай хуулиуд;

Сэдэв №3 “Галын аюулгүй байдлын тухай” хууль, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм;

Сэдэв №4 Осолд өртөгсдөд үзүүлэх эмнэлгийн анхны тусламжийн тухай;

Сэдэв №5 Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм;

Тэмцээний I шатанд оролцож буй 9 баг 3 хэсэгт хуваагдаж, багууд хэсэг тус бүртээ дээрх 5 сэдвийн хүрээнд 5 үе тоглож, нийт 15 асуултанд хариулан өрсөлдсөн бөгөөд хэсэг тус бүрээс хамгийн өндөр оноо цуглуулсан механик цехийн “Genius squad”, турбин цехийн “Илч - Энерги”, алба, хэлтсийн “Таван Од” багууд тэмцээний II шат буюу шигшээ тоглолтонд өрсөлдөхөөр шалгарсан.

Тэмцээний асуулт, хариулыг (0; 2,5; 5) оноогоор ил тод дүгнэсэн. Үүнд:

- ❖ Хариулах эрхийн кнопыг урьтан дарж, асуултанд зөв хариулсан багт 5 оноог тооцсон.
- ❖ Асуултанд буруу хариулсан, эсвэл хариулаагүй багт 0 оноог тооцсон.
- ❖ Асуултанд хариулах боломжийг ашиглах эрхийг эдэлж, зөв хариулсан багт 2,5 оноог тооцсон.

Тэмцээний шигшээ тоглолт эхлэхээс өмнө хөгжөөн дэмжигчдийн дундах тэмцээнийг дээрх зарчмаар зохион байгуулсан бөгөөд нийт 4 оролцогчоос хими цехэд сорьц бэлтгэгч М.Эрдэнэтуул(15 оноо) тэргүүлж, хими цехэд түлш тосны техникч Г.Батцэцэг(5 оноо)

удаалж, захиргаа, удирдлагын хэлтэст нууцын ажилтан Л.Алтансүх(5 оноо) нэмэлт тоглолтын үр дүнгээр гутгаар байрт шалгарч, тус тус мөнгөн шагналаар шагнуулав.

Тэмцээний II шат буюу шигшээ тоглолтыг I шатны зарчмаар зохион байгуулж, дүгнэхэд дараах байдлаар байр эзэллээ. Үүнд:

- |  |         |
|--|---------|
| ❖ Тэргүүн байранд "Genius squad" баг (Механик цех) | 55 оноо |
| ❖ Дэд байранд "Илч - Энерги" баг (Турбин цех)      | 30 оноо |
| ❖ Гутгаар байранд "Таван Од" баг (Алба, хэлтэс)    | 25 оноо |

Тэмцээнд амжилттай оролцож, эхний 3 байрт шалгарсан багуудыг Өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулав.

Тэмцээнд оролцсон баг тус бүрийн мэдүүлэг, баримтжуулсан үнэлгээний дүнгийн хуудас, тэмцээний үеийн зураг, өргөмжлөлийн зураг зэргийг хавсаргав.

Танилцсан:		Б.Сурмаахорол (ХАБЭАЗ-ийн дарга)
Хянасан:		Б.Ганбат (ДХХ-ийн дарга)
Тайлагнасан:		Д.Отгонбат (ХАБЭА инженер)

Тэмцээний үеэр баримтжуулсан зургуудаас . . .



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сэдэвт  
"Центавр" удирдамжит тэмцээний үнэлгээний хуудас

I шат: А хэсэг																			
№	Багуудын нэр	Сэдэв №1 (ААД)			Сэдэв №2 (Хууль)			Сэдэв №3 (ГАБ)			Сэдэв №4 (ЭАТ)			Сэдэв №5 (ӨЗММ)			Нийлбэр оноо	Байр	
		Асуулт			Асуулт			Асуулт			Асуулт			Асуулт					
		I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III			
1	"Мэдрэмж" (ДХХА цех)	-	-	5	2,5	-	-	0	-	-	0	2,5	0	-	-	-	10	II	
2	"Genius squad" (Механик цех)	2,5	5	-	-	5	5	0	5	2,5	0	-	0	-	2,5	5	32,5	I	
3	"Fire" (Зуухан цех)	-	-	-	-	-	-	0	-	-	0	-	0	2,5	-	-	2,5	III	
I шат: В хэсэг																			
№	Багуудын нэр	Сэдэв №1 (ААД)			Сэдэв №2 (Хууль)			Сэдэв №3 (ГАБ)			Сэдэв №4 (ЭАТ)			Сэдэв №5 (ӨЗММ)			Нийлбэр оноо	Байр	
		Асуулт			Асуулт			Асуулт			Асуулт			Асуулт					
		I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III			
1	"Илч - Энерги" (Турбин цех)	0	2,5	-	5	-	0	-	-	5	5	-	-	-	-	5	22,5	I	
2	"Secure X" (Хими цех)	0	-	5	-	-	0	-	2,5	-	-	-	5	5	-	-	17,5	II-III	
3	"Dark flame" (ТД цех)	0	-	-	-	5	0	2,5	-	-	-	5	-	-	5	-	17,5	II-III	
I шат: С хэсэг																			
№	Багуудын нэр	Сэдэв №1 (ААД)			Сэдэв №2 (Хууль)			Сэдэв №3 (ГАБ)			Сэдэв №4 (ЭАТ)			Сэдэв №5 (ӨЗММ)			Нийлбэр оноо	Байр	
		Асуулт			Асуулт			Асуулт			Асуулт			Асуулт					
		I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III			
1	"Таван Од" (Алба, хэлтэс)	5	5	-	0	0	0	-	5	-	0	-	2,5	0	5	0	22,5	I	
2	"Electro" (Цахилгаан цех)	-	-	-	0	0	0	-	-	5	0	5	-	0	-	0	10	II-III	
3	"Джоуль" (ДШС цех)	-	-	5	0	0	0	5	-	-	0	-	-	0	-	0	10	II-III	

II шат: Шигшээ																			
№	Багуудын нэр	Сэдэв №1 (ААД)			Сэдэв №2 (Хууль)			Сэдэв №3 (ГАБ)			Сэдэв №4 (ЭАТ)			Сэдэв №5 (ӨЗММ)			Нийлбэр оноо	Байр	
		Асуулт			Асуулт			Асуулт			Асуулт			Асуулт					
		I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III			
1	"Таван Од" (Алба, хэлтэс)	-	0	-	0	0	-	-	-	0	0	-	0	2,5	-	-	2,5	III	
2	"Genius squad" (Механик цех)	2,5	0	-	0	0	5	-	5	0	0	5	0	-	2,5	2,5	22,5	I	
3	"Илч - Энерги" (Турбин цех)	-	0	5	0	0	-	2,5	-	0	0	-	0	-	-	-	7,5	II	
Нийлбэр оноог сийрүүлбэл:																			
I байр										"Genius squad" баг (механик цех)					55 оноо				
II байр										"Илч - Энерги" баг (турбин цех)					30 оноо				
III байр										"Таван Од" баг (алба, хэлтэс)					25 оноо				
Хөгжөөн дэмжигчдийн тэмцээн:																			
№	Багуудын нэр	Сэдэв №1 (ААД)			Сэдэв №2 (Хууль)			Сэдэв №3 (ГАБ)			Сэдэв №4 (ЭАТ)			Сэдэв №5 (ӨЗММ)			Нийлбэр оноо	Байр	
		Асуулт			Асуулт			Асуулт			Асуулт			Асуулт					
		I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III			
1	Л.Алтансүх	0	-	0	0	-	0	-	0	0	-	-	0	0	0	0	0	0	III
2	М.Эрдэнэтуул	0	-	0	0	5	0	2,5	0	0	5	2,5	0	0	0	0	15	I	
3	Г.Батцэцэг	0	5	0	0	-	0	-	0	0	-	-	0	0	0	0	5	II	
4	Т.Баярсайхан	0	-	0	0	-	0	-	0	0	-	-	0	0	0	0	0	IV	

Танилцсан:



Б.Сурмаахорол  
(ХАБЭАЗ-ийн дарга)



Б.Ганбат  
(ДХХ-ийн дарга)

Хөтөлсөн:



Ё.Тунгалаг  
(ХАБЭА инженер)



Ажил мэргэжлийн уралдааны шагнал:

Багийн дүнгээр 1-р байр 300,000 төг бүхий INGCO брэндийн багаж хэрэгсэл  
2-р байр 200,000 төг бүхий INGCO брэндийн багаж хэрэгсэл

1. Дэвтэр 4ш \*10,000төг = 40,000 төг
2. Үзэг 4ш\*8,500 төг = 34,000 төг
3. INGCO брэндийн багаж = 426,000 төг  
Нийт 500,000 төг





## Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр

Үйлдвэрлэлийн осол, МШӨ-өөс урьдчилан сэргийлэх, ажлын байранд тохиолдож болзошгүй аюул, эрсдэлийг бууруулах зорилгоор “Зөв хандлагатай байж, Зөв дадлыг төлөвшүүлье” уриан дор нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

- Өглөөний ХАБ үйл ажиллагааг цехүүдийн хэсэг тус бүрт өглөө бүр 10-15 минутанд хийж хэвшсэн. Оны эхнээс нийт 1891 удаа Өглөөний ХАБ хийсэн.
- “Аюулыг мэдээлье, эрсдэлийг бууруулая” аян
- Осол, аюул, эрсдэлгүй ажиллагч хамт олон болзолт уралдаан /жилийн турш/
- Шинэ ажилтнуудын дунд “АХА” асуулт хариултын тэмцээн
- Цахим сүлжээгээр урьдчилан сэргийлэх, анхааруулах мэдээлэл түгээх
- ХАБЭА-н чиглэлээр “Центавр” тэмцээн жил бүр зохион байгуулдаг





Центавр тэмцээн



Шинэ ажилтнуудын АХА тэмцээн

# АЮУЛЫГ МЭДЭЭЛЬЕ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛЪЯ

НЭГ САРЫН АЯН



## Зорилго

Ажлын байрны аюулыг илрүүлэх, мэдээлэх, эрсдэлийг бууруулах, аюулгүй орчныг бүрдүүлэхэд ажилтан бүрийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх, ажлын байрны ажиглалтыг хийх, аюулыг таних, илрүүлэх дадал, зуршлыг хэвшүүлэх, төлөвшүүлэхэд оршино.



## Хамрах хүрээ

“ЭДЦС” ТӨХК-ийн бүтцийн нэгжүүдийн ИТА, ажилтнууд



## Хугацаа

2025 оны 02-р сарын 03-аас  
2025 оны 03-р сарын 04



## Аюулыг мэдээлэх суваг

- Цахимаар буюу QR код уншуулан [Erdenetpp.com](http://Erdenetpp.com) хуудсаар мэдээлэх
- Аюулыг мэдээлэх хэвлэмэл хуудсаар мэдээлэх



## Анхаарах зүйлс

Аюулыг мэдээлэхдээ аюулын байршил, үүсэх эрсдэлийн талаарх мэдээллийг тодорхой, ойлгомжтой бичиж, хуудасны эх хувийг хайрцагт хийн, нөгөө хувийг өөрийн хэсгийн инженер, мастер, ахлах ажилтанд өгнө.



Аяны хугацаанд хамгийн олон аюулыг илрүүлж мэдээлсэн ажилтнуудыг урамшуулна.



[Erdenetpp.com](http://Erdenetpp.com)



**ЗӨВ** ХАНДЛАГА  
ДАДАЛ

Дотоод хяналтын  
ХЭЛТЭС



Сарын аяны арга хэмжээ

Нийт ажилтны сургалт



**"ЭДЦС" ТӨХК-ийн "ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАХИН"  
ҮНЭЛГЭЭ ХИЙХ" АЖЛЫН ДААЛГАВАР**

**1.Зорилго:**

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны 06 дугаар сарын 30-ний өдрөөрх санхүүгийн тайланд бүртгэлтэй 17.6 тэр бум төгрөгийн өртөгтэй, 17.6 тэр бум төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 0 төгрөгийн үлдэгдэл өртөгтэй, 1,401 нэр төрлийн үндсэн хөрөнгө (барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер техник хэрэгсэл), биет бус хөрөнгө (программ хангамж, зохиогчийн эрх, газрын эрх)-ийг Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Хөрөнгийн үнэлгээний олон улсын стандарт, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн дахин үнэлгээ хийж, тухайн өдрийн байдлаарх бодит үнэ цэнийг тогтоох, ашиглалтын хугацааг тодорхойлох.

**2. Дахин үнэлгээ хийх ажлын агуулга**

1."ЭДЦС" ТӨХК-ийн санхүүгийн тайланд бүртгэлтэй нийт (барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер техник хэрэгсэл), биет бус хөрөнгө (программ хангамж, зохиогчийн эрх, газрын эрх) Хөрөнгийн үнэлгээний тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол улсын хууль болон Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Хөрөнгийн олон улсын стандарт дүрэм журамд нийцүүлэн дахин үнэлгээ хийж тус өдрийн байдлаарх бодит үнэ цэнийг тогтоох, ашиглалтын хугацааг тодорхойлох.

2. Гүйцэтгэгч нь үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгөнд дахин үнэлгээ хийж бодит үнэ цэнийг тодорхойлох ажлыг нарийн цаг хугацаатайгаар төлөвлөж гүйцэтгэх.

3. Өмнөх дахин үнэлгээний үр дүнтэй уялдуулан бодит үнэ цэнийн өсөлт бууралтыг тодорхойлох, Нягтлан бодох бүртгэлд тусгах аргачлал, зааварчилгаа гаргаж өгөх.

4. Багцлан бүртгэсэн хөрөнгийг хийц хэсгийн элементээр задалж, нэгтгэх асуудлыг өмч хамгаалах байнгын зөвлөл буюу холбогдох цех хэлтсийн даргатай хамтран үнэлэх.

5. Санхүү, татварын зорилгоор элэгдэл байгуулах, хойшлогдсон хөрөнгө, өр төлбөрөөр бүртгэх боломжтойгоор үнэлгээ хийх.

**3. Үзүүлэх үйлчилгээ, үр дүн**

1. "ЭДЦС" ТӨХК-ийн тухайн өдрийн байдлаарх үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн ангилал, кодчилал, ашиглалтад орсон огноо, цаашид ашиглагдах хугацаа, үнэлсэн өртөг, хуримтлагдсан элэгдэл, бодит үнэ цэнэ, дахин үнэлгээний нэмэгдэл, үнэ цэнийн бууралт,

техникийн үзүүлэлт, чанар байдлын үнэлгээ, үнэлгээний арга хандлага зэргийг тусгасан тайланг эксел файлаар болон хэвлэмэл ном байдлаар гаргана.

2. Дахин үнэлгээг гэрээ байгуулснаас хойш 90 /ерэн/ хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

3. Гүйцэтгэгч нь ажлын даалгаварт нийцсэн үйлчилгээ үзүүлэх бөгөөд талууд ажил гүйцэтгэж дууссаны дараа акт үйлдэн хүлээлцэнэ.

4. Хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн хөрөнгийг санхүүгийн программд бүртгэх, аргачлал, үр дүнг санхүүгийн тайланд хэрхэн тусгах талаар инженер техникийн болон санхүү бүртгэлийн ажилтнуудад сургалт зохион байгуулах.

5. Үйлчилгээ гүйцэтгэх явцад илэрсэн асуудлаар цаг тухай бүр захиалагчтай хэлэлцэн шийдвэрлэх.

6. Үйлчилгээ үзүүлэх явцад хөрөнгийн бүртгэлтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрсэн тохиолдолд залруулга хийх зөвлөгөө өгөх.

7. Үйлчилгээ үзүүлэх явцад хөрөнгийн хувийн хэрэг мэдээлэл, программ хангамжийн мэдээлэл зөрүүтэй бол захиалагчид мэдэгдэн залруулах арга хэмжээ авах.

8. Гүйцэтгэгч нь асуудлыг оновчтой шийдвэрлэн зөвлөгөө өгөх, ажлаа хугацаанд нь чанартай хийж дуусгах чадвартай багийг ажиллуулах.

9. Үйлчилгээ үзүүлэх багийн ахлагч нь хөрөнгийн үнэлгээ хийх хугацаагүй эрхээ авсан байх, багийн гишүүд нь 3 дээш жил ажилласан зохих дадлага, туршлагатай баг байна. Багийн гишүүдийн 3 нь тус компанийн үндсэн ажилтан байна.

10. Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой гарах бүх зардал нь гэрээний үнэд багтсан байна.

№	Дансны нэр	Нэр төрөл	Тоо хэмжээ	Балансын үнэ	Элэгдэл	Үлдэх өртөг
1	Барилга байгууламж	5	5,042.00	47,166,328	47,166,328	0
2	Машин тоног төхөөрөмж	854	995.97	16,879,001,133	16,879,001,133	0
3	Тээврийн хэрэгсэл	1	1.00	9,813,300	9,813,300	0
4	Тавилга эд хогшил	393	592.00	200,272,087	200,272,087	0
5	Компьютер, техник хэрэгсэл	140	163.00	470,231,057	470,231,057	0
6	Биет бус хөрөнгө	8	8.00	39,051,100	39,051,100	0
<b>Нийт дүн</b>		<b>1,401</b>	<b>6,801.97</b>	<b>17,645,535,005</b>	<b>17,645,535,005</b>	<b>0</b>

#### 4. Гүйцэтгэгчид тавигдах үндсэн шаардлага:

1. Гүйцэтгэгч нь хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компани байх бөгөөд эрчим хүчний салбарын байгууллагад хөрөнгийн үнэлгээ хийсэн туршлагатай байна.

2. Үйлчилгээ нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Үнэлгээний олон улсын стандарт болон Монгол улсын хууль, дүрэм, журамд нийцэж байх.

2. Ажил үүргийг гүйцэтгэх явцад Захиалагчтай харилцан уялдаа холбоотой ажиллана. Харилцан уялдаа холбоотой ажиллагаа гэдэгт ажлын явцад боловсруулах баримт бичгийн талаар зөвлөгөө авах, зөвшилцөх, захидал бичгээр харилцах явдал юм.

3. Гүйцэтгэгч нь дахин үнэлгээ хийх явцад олж авсан захиалагчийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулахгүй байх, өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ажиллах.

#### ХЯНАСАН:

ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ,

СБЭЗХ-ИЙН ДАРГА



СУРМААХОРОЛ

Б.ЗУЛЦЭЦЭГ - 2

#### БОЛОВСРУУЛСАН:

НЯГТЛАН БОДОГЧ



Д.ПҮРЭВСҮРЭН